



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2019 оны 06 сарын 05 өдөр

Дугаар А/389

Арвайхээр

Хөрөнгө зарцуулах тухай


Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 2/01 дүгээр тогтоолоор батлагдсан аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны “Бүтээлч Өвөрхангай-2020” хөтөлбөрийн 4.1.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Баян-Өндөр сумын иргэдийн Төлөөлөгчдийн хурлын автомашины засварын зардалд 5,000,000, Баруунбаян-Улаан сумын Засаг даргын Тамгын газрын автомашины засварын зардалд 2,000,000, Баянгол сумын Засаг даргын Тамгын газрын автомашины засварын зардалд 2,000,000, Өлзийт сумын Засаг даргын Тамгын газрын автомашины зардалд 5,000,000 төгрөгийг тус тус зарцуулсугай.

2. Бүгд найрамдах Турк улсын мэргэшсэн нягтлан бодогчдын холбоо, Монголын мэргэшсэн нягтлан бодогчдын институтын хамтын ажиллагаанд оролцох Өвөрхангай салбарын гишүүний ирэх очих замын зардалд 2,200,000 (хоёр сая хоёр зуун мянга) төгрөгийг зарцуулсугай.

3. Дээрх зардалд 16,200,000 (арван зургаан сая хоёр зуун мянга) төгрөгийг үндсэн чиглэл хэрэгжүүлэх зардлаас санхүүжүүлэхийг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэс (Д.Нэмэхбаяр)-т зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100634